

ТҮҮХ Х АНГИ
“Бие даан суралцах ажлын дэвтэр”

**Бүрэн дунд боловсролын Түүхийн сурлагын хоцрогдлыг нөхөх,
 арилгах “Бие даан суралцах ажлын дэвтэр”-ийн сурагчдад өгөх
 зөвлөмж**

Бие даан ажиллах дэвтрийн дасгал, даалгаврын түвшин, тэмдэглэгээ:

Тэмдэглэгээ	Тайлбар
10.1a	10 - Анги 1 – I түвшний даалгавар (улаан өнгө) 2 – II түвшний даалгавар (шар өнгө) 3 – III түвшний даалгавар (ногоон өнгө) а – Даалгаврын дугаар (Жишээ: а-1, б-2, в-3 гэх мэт)
10.2a	
10.3a	

Суралцахуйн зураглалтай ажиллах алхам:

I алхам:	Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай.
II алхам:	Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр булаарай.
III алхам:	Тухайн бүлгийн дасгал, даалгаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг заавал тэмдэглээрэй.
IV алхам:	Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй.
V алхам:	Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулаарай.

Т А Н И Х Т Э М Д Э Г

Торлох зам

Хуралданы зам

Цагаан хэргийн тэмдэг

Хуралданы үеийн болон Ерөнхий

Хуралданы болон хуралданы түүх

МТ

МТЭ

ХАНЬ УЛС

ЦСШСШ

Содол

Хуралданы үеийн

Хуралданы үеийн

Хуралданы үеийн

Хуралданы үеийн






Хуралданы үеийн

Хуралданы үеийн

Бүлэг сэдэв: Түүх судлах аргууд
Сурагчийн овог нэр

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дууссан.... он.....сар.....өдөр....цаг

Агуулга

1. Дасгал ажлын судлах сэдвүүд	<ul style="list-style-type: none">❖ Түүх судлах аргууд❖ Түүхийг судлах аргаа хэрэглэх
2. Дасгал ажлын дэвтрийн таних тэмдэг	 Сэдвийн агуулга
	 Баримт, мэдээллийг уншаад асуултад хариулаарай.
	 Дасгал ажил
	 Баримт мэдээллийг шинжлээрэй.
	 Нэр томъёоны тайлбар

Т А Н И Х Т Э М Д Э Г

- | | | |
|--|---|--|
|  Торгоны зам |  Хүннугийн үеийн Бээж, Ерөнги | ХАНЬ УЛС  Хүннугийн үеийн дэргэдэг |
|  Худалдааны зам |  Хүннугийн Бээжт, хэрэгцээний түүх | ЦСХУ  Хань улсын цагдаагийн дэргэдэг |
|  Шинжлэх ухааны зам | НТ Манай тосгоныг | Содол  Хүннугийн үеийн дэргэдэг |
|  Шинжлэх ухааны зам | МТЭ Манай тосгоныг өмнө | |

Түүх судлах аргууд

- Агуулгын хураангуй
- Түүхийг судлахад гол хэрэглэдэхүүн бол эх сурвалж юм. **Анхдагч сурвалж** гэдэг нь тухайн судалж буй үйл явдал, түүхэн цаг үед бүтээгдсэн юм уу тэрхүү цаг үеэс арай хожуухан бүтээгдсэн эд зүйлс болон бичмэл тэмдэглэлүүд юм. **Хоёрдогч эх** сурвалжууд нь ихэвчлэн өнгөрсөнд болсон үйл явдлуудыг нэгтгэн ямар нэг ойлгомжтой байдлаар хүүрнэл хэлбэрт оруулан найруулсан “бичмэл текст”-үүд юм.

Даалгавар 10.1а. Дараах сурвалжуудын аль нь анхдагч болон хоёрдогч болохыг тодорхойлж ангилж бичнэ үү.

- Гүүг хааны тамганы дардас, Чингисийн чулууны бичиг, Өлзийт хааны захидал, Мандухай цэцэн хатан кино, Хүн гүрэн баримтат кино, Монгол улсын түүх 5 боть, Марко Поло Орчлонгийн элдэв сонин, Их Монгол улс газар зүйн зураг, чулуун зэвсэг

Анхдагч сурвалж	Хоёрдогч сурвалж
	

Даалгавар 10.1б. Дараах монголын түүхийн үеүдийг үндсэн болон дэд үеэр нь цаг хугацааны дагуу эхнээс нь зөв байршуулж бичнэ үү.

Монголын өвөг түүхийн үе, хүрэл, түрүү төмрийн үе, Хүннү гүрэн, монголын эртний улсууд, Монгол нутаг дахь түрэг угсааны улсууд, чулуун зэвсгийн үе

.....
.....
.....
.....
.....
.....

Даалгавар 10.1в. Дараах түүхийн үечлэлийг холбогдох он цагтай нь зөв тохируулна уу.

- | | |
|----------------------------|------------------------------------|
| A. Монголын палеолит | 1. 8000 жилийн өмнө-НТӨ III мянган |
| B. Мезолит | 2. 800 000-12 000 жилийн өмнө |
| C. Неолит | 3. НТӨ III мянган-НТӨ IV зуун |
| D. Хүрэл, төмрийн түрүү үе | 4. 12 000-8000 жилийн өмнө |

Даалгавар 10.1г. Дараах түүхийн үе тус бүрд холбогдох эх сурвалжуудаас нэрлэж бичнэ үү.


- а. Олзворлох түүвэрлэх аж ахуйн үе
-
 -
 -
- б. Үйлдвэрлэх аж ахуйн үе
-
 -
 -
- в. Хүрлийн үе, түрүү төмрийн үе
-
 -
 -
- г. Хүрлийн үе, түрүү төмрийн үе
-
 -
 -
- д. Монгол нутаг дахь эртний улсуудын үе
-
 -
 -

Даалгавар 10.2а Түүхийн үе тус бүрд холбогдох эх сурвалжийг бичихэд гол онцлог юу байгааг тодорхойлж бичнэ үү.

Өвөг түүхийн үе	Эртний улсуудын үе
-	-
-	-
Т А Н И Х Т Э М	Д Э Г
-	-
-	-
-	-
-	-

Сурвалжийг тайлбарлах арга

- Аливаа түүхэн үйл явдлыг судлахын тулд уг үйл явдалд холбогдох анхдагч сурвалжуудыг шалгах шаардлагатай. Учир нь тухайн сурвалж алдаатай байж болох юм. Үүний тулд дараах зарчмыг баримтлана.
- Теле хичээл: <https://econtent.edu.mn/lessons/EBS/10rangj/tuuh/2989>



Даалгавар 10.26. Дараах сурвалжийн мэдээг анхааралтай уншаад дээрх аргачлалын дагуу тайлбарлана уу.

- **Сурвалж**
- **Сыма Цяний НТӨ 110-91 онд бичсэн “Түүхэн тэмдэглэл”-ийн 110-р бүлэг, “Хүннүгийн шаштир”-аас.**
- “Энэ үед Дунху хүчирхэгжин, Юэжи цэцэглэн мандаж байсан бөгөөд Хүннүгийн шаньюй Түмэн байв”. Дунху нар “Хүннүтэй нэгэн зэрэг мандан гарсан бөгөөд нум сумт цэрэг 200 мянга гаруй буй. Зан заншил, түшмэдийн цол нь Хүннүтэй адил”.

Эх сурвалж: Ц. Гантулга нар. Монголын түүх X сурах бичиг 17-р тал. УБ.2017

а. Ямар сурвалж вэ?

.....
.....

б. Хэн бичсэн бэ?

.....
.....


в. Хэнд зориулан бүтээсэн бэ? Яагаад?

.....
.....

г. Хаана хэзээ бичсэн бэ? Одоогоос хичнээн жилийн өмнө бичигдсэн байна вэ?

.....
.....

Эх сурвалжтай ажиллах арга барил



Даалгавар 5. 10.3а. Дараах сурвалжийн мэдээг дээрх арга барилын дагуу судлан асуултад хариулж бичнэ үү.

- **Умард Вэй улсын түүхэн сурвалжаас.**
- 429 онд Умард Вэй улсын Шизу хаан Жужаныг довтлохоор түшмэдтэйгээ зөвлөлдөхөд ихэнх түшмэд нь Жужантай дайтах хааны саналыг дэмжсэнгүй. Тэд хаанд дараах айлтгалыг өргөв. Айлтгасан нь: Энэ шарагчин могой гурван билгийн жил, Бархасбадь гараг...Сугар гараг өрнө зүг байна. Цэрэг хөдөлгөж умар зүг довтолж болохгүй, ялаа ч гэсэн дээдэст золгүй болно”.
- **Эх сурвалж: Ц. Гантулга нар. Монголын түүх Х сурах бичиг. 23-р тал УБ.2017**

Эх сурвалж бидний гарт ямар замаар дамжиж ирсэн бэ? Эх хувь мөн үү? Хуулбар уу?

.....
.....

Нэмэлт материал, мэдээлэл ашиглан дэлгэрүүлэн тайлбар хийнэ үү. / Монголын түүх Х сурах бичгийн 22-25-р хуудсыг ашиглана уу./

.....
.....
.....

Ямар шалтгаанаар юуны учир бичих болсон бэ?

.....
.....

Тухайн сурвалжийн талаар өөрийн дүгнэлтийг бичнэ үү.

.....
.....
.....
.....

Даалгавар Дараах сурвалжийг шинжлээрэй.

СУРВАЛЖ

Монгол нутгаас олдсон түрүү төмрийн үеийн эрэгтэй хүний булш. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Олон гүүрийн гол.

2006 онд олон улсын судалгааны баг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт орших Алтайн нурууны мөнх цэвдэгт өндөрлөгөөс НТӨ IV-III зууны үеийн эрэгтэй хүний булшийг илрүүлжээ. Түүний шарил мөнх цэвдгийн улмаас занданшсан ажээ. Түүнийг хонины ноос, тарваганы арьс хослуулан урласан нарийн хийцтэй дээл, шовгор малгай, төмөр чинжаал хутга, байлдааны зээтүү, махчин шувууны толгойтой домгийн амьтны модон дүрс, модон тэвштэй бог малын ууц, хоёр адуу, эмээл хазаар зэрэг морины иж бүрэн тоног хэрэгсэл дагалдуулан оршуулсан ажээ.



:Даалгавар 10.36. Дээрх сурвалжийг үндэслэн ямар дүгнэлт хийж болох вэ?

а). Бог малын ууц, хоёр адуу, морины тоног хэрэглэл

-
-

б). Хонины ноос, тарваганы арьс хослуулсан дээл

-
-

в). Төмөр чинжаал хутга, байлдааны хутга

-
-

г). Махчин амьтны модон дүрс

-
-

д). Эдлэл хэрэглэл, мал, хоол хүнс зэргийг дагалдуулж оршуулсан нь

-
-






Санамж: Теле хичээл

<https://econtent.edu.mn/lessons/EBS/10rangji/tuuh/3387> -ээс дэлгэрүүлж үзээрэй. .

Бүлэг сэдэв: Монголын өвөг түүх
(800 000 жилийн өмнө-НТӨ IV зуун)
Сурагчийн овог нэр

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дууссан.... он.....сар.....өдөр....цаг

Агуулга

1. Дасгал ажлын судлах сэдвүүд	<ul style="list-style-type: none">❖ Палеолит, мезолит: Олзворлох, түүвэрлэх аж ахуйн үе❖ Неолитын хувьсгал: Үйлдвэрлэх аж ахуйн үе❖ Хүрлийн үе, түрүү төмрийн үе: Нүүдлийн иргэншил
2. Дасгал ажлын дэвтрийн таних тэмдэг	 Сэдвийн агуулга
	 Баримт, мэдээллийг уншаад асуултад хариулаарай.
	 Дасгал ажил
	 Баримт мэдээллийг шинжлээрэй.
	 Нэр томъёоны тайлбар

- Дараах дасгал даалгаврыг гүйцэтгэхдээ сурах бичгийн 7-16-р тал
- Теле хичээл: <https://econtent.edu.mn/lessons/EBS/10rangj/tuuh/3607>
- <https://econtent.edu.mn/lessons/EBS/10rangj/tuuh/3814> ашиглаарай.

Даалгавар 10.1а. Дараах чулуун зэвсгүүдийг зөв оноож нэрлэнэ үү.

А. Чулуун самбар нухуур

1.



В. Чулуун зэв

2.




С. Зуулга иртэй хутга

3.



Д. Нэхүүрийн ясан зүү

В.



Е. Сөрлүүрт ясан жад

В.



Ф. Чулуун сүх

В.



Даалгавар 10.1б. Дараах чулуун зэвсгүүдийг үүрэг зориулалтаар тохируулна уу.



1. Сөрлүүрт ясан жадаар загас барьж байсан.



2. Нум сумаар ан хийж байсныг илтгэж байна.



3. Үр тариа нухаж боловсруулах зориулалттай.



4. Модоор юм урлахад ашиглаж байв.



5. Үс, ноос ээрч хувцас хийхэд ашиглаж байв.



6. Юм огтлох, зүсэхэд ашиглана.

Даалгавар 10.1в. Тус чулуун зэвсгийн үеүдэд ямар багаж зэвсгүүд үүссэн болохыг тохируулна уу.

1. Доод палеолит
2. Дунд палеолит
3. Дээд палеолит
4. Мезолит
5. Неолит

- A. Жад
- B. Шовх ялтсан хутга
- C. Тариа цайруулах самбар
- D. Үлдэц, цуулдас
- E. Нум сум

Даалгавар 10.2а. Дараах чулуун зэвсгийг бий болсон цаг хугацааны дагуу 1-4 тоогоор эрэмбэлнэ үү.



б. Юуг үндэслэж энэ эрэмбийг хийх болсон шалтгаанаа тодорхойлж бичнэ үү.

.....

.....

.....

.....


Монголын өвөг түүх (800000-НТӨ IV зуун)

Даалгавар 10.3а. Дараах чулуун зэвсгийн үе тус бүрд тохирох ойлголтыг харьцуулж тодорхойлж бичнэ үү.


Чулуун зэвсгийн үе шат	Багаж зэвсэгт гарсан өөрчлөлт	Тухайн үе тус бүрийн гол онцлог
Доод палеолит	-	-
Дунд палеолит	-	-
Дээд палеолит	-	-
Мезолит	-	-
Неолит	-	-

Товч агуулга: Монгол нутагт өвөг хүмүүс амьдарч байсныг илтгэх дурсгал нь Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн голын хөндийн бууц суурин, мөн аймгийн Баянлиг сумын Цагаанй агуй, Өмнөговь аймгийн Цахиуртын хөндий, Дундговь аймгийн Ярх уул, Ёроол говь, Өвөрхангай аймгийн Гучин Ус, Ховд аймгийн Баралгийн гол, Дорноговь аймгийн Сайншанд зэрэг газруудаас доод палеолитын үед холбогдох бууц суурингууд олджээ.

Даалгавар 10.3б. Монголын доод палеолитын бууц суурингууд хаагуур тархсан байгааг газар зүйн зурагт тэмдэглэж бүс нутгийг тодорхойлно уу.



Даалгавар 10.2б. Дараах нэргүй газар зүйн зурагт дурсгалууд хаанаас олдсон болохыг тэмдэглэнэ үү.



Даалгавар 10.3в. Дээрх багаж зэвсэг нь чулуун зэвсгийн аль үед холбогдохыг тодорхойлно уу..

а.....
.....
.....

б. Тухайн багаж зэвсэг бий болсноор аж ахуй, болон хүмүүсийн амьдралд ямар өөрчлөлт гарсныг үнэлэлт өгч таамаглал дэвшүүлнэ үү.

.....
.....
.....



Дасгал ажил 10.3г. Дараах аж ахуйн ялгаа онцлогыг харьцуулаарай.

	Олзворлох, түүвэрлэх аж ахуй	Үйлдвэрлэх аж ахуй
Багаж зэвсэгт гарсан өөрчлөлт		
Аж ахуйд гарсан өөрчлөлт		
Хүмүүсийн амьдралд гарсан өөрчлөлт		

Дасгал ажил 10.3д Дараах асуултад үнэлэлт дүгнэлт өгч хариулж бичнэ үү.

а. Үйлдвэрлэх аж ахуй үүссэн нь хүмүүсийн амьдралд ямар эерэг нөлөө үзүүлсэн бэ?

.....

.....

.....

.....

б. Неолитын үед монгол оронд оршин суугчид үйлдвэрлэх аж ахуйд шилжснийг баримтад үндэслэн тайлбарлаж бичнэ үү.

.....

.....

.....

.....

в. “Чулуун зэвсгийн үечлэл” хийх болсон шалтгааныг тодорхойлж бичнэ үү

.....

.....

.....

.....

г. Олзворлох, түүвэрлэх болон үйлдвэрлэх аж ахуй гэж ялгах болсон шалтгааныг тодорхойлж бичнэ үү.

.....

.....

.....

.....

Хадны зураг: Хадан дээрх зураг. Хадны зургийг бүтээсэн аргаар нь сийлмэл, зосон гэж хоёр ангилдаг. Хадны зураг нь гол төлөв өвөг түүхийн үед хамаардаг. Гэвч хожуу үеийн зургууд цөөнгүй олддог билээ.

Даалгавар 10.3е. Дараах зургуудыг ажиглаад асуултад хариулна уу.



а. Дээрх хоёр зураг түүхийн аль үед холбогдох вэ? Энэхүү зургуудыг ямар зорилгоор зурсан бэ?


.....
.....

б. Хойд Цэнхэрийн агуйн зураг ба Чаньдмань Хар үзүүрийн зургуудын ижил ба ялгаатай тал юу вэ?

Ижил тал

Ялгаатай тал

в. Дээрх зургуудыг дараах нэргүй газар зүйн зурагт аль аймгийн нутагт байдгийг зургийн өмнөх дугаараар тэмдэглэнэ үү.



Хэрвээ та энэ асуултад хариулахад хүндрэлтэй байвал сурах бичгийн 11-р хуудаснаас үзнэ үү.

Даалгавар 10.3е Дараах ойлголтыг тайлбарлаж бичнэ үү.

а. “Неолитын хувьсгал” гэж нэрлэх болсон учрыг тодорхойлж бичнэ үү.

.....
.....
.....

б. Неолитын үед үүсэж өнөө үед уламжлагдан ирсэн аж ахуйн талаар өөрийн саналыг тайлбарлаж бичнэ үү.

.....
.....
.....

Даалгавар. 10.3ё. Дараах зургийг ажиглаад асуултад хариулна уу.



а. Энэхүү зургийг ямар зорилгоор зурсан бэ?

.....
.....

б. Зурагт дүрслэгдсэн зарим амьтад устаж үгүй болоход нөлөөлсөн хүчин зүйлийг тайлбарлаж бичнэ үү.

.....

Т А Н И Х Т Э М Д Э Г

.....

NT - Мөний тосголт
MTE - Мөний тосголын өмнө

Дасгал ажил 10.3ж. Түүхийн эрт үеэс бидэнд өвлөгдөж ирсэн дараах соёлын биет өвүүдийн талаар бусдад зориулсан танилцуулга хийнэ үү.

а. Хадны зураг

-

б. Буган хөшөө

-

в. Хиргисүүр

-

г. Дөрвөлжин булш

-

Даалгавар 10.3з. Дээрх түүхийн дурсгалуудын ижил болон ялгаатай талыг гаргаж бичнэ үү..

Түүхийн дурсгалууд	Төстэй тал	Ялгаатай тал
3. Хиргисүүр		
4. Дөрвөлжин булш		

Дасгал ажил 10.3и. Монгол нутагт амьдран суугчид мал аж ахуй эрхлэх болсон шалтгааныг тодорхойлж бичнэ үү. Дараах теле хичээлийг ашиглаарай.

<https://econtent.edu.mn/lessons/EBS/10orange/tuuh/3387>

-
-
-

Дасгал ажил 10.2г. Нүүдлийн иргэншлийн талаарх дараах ойлголтуудыг тайлбарлан бичнэ үү..

а. Нүүдлийн иргэншил

.....
.....

б. Мал аж ахуй

.....
.....

в. Нүүдэлчид

.....
.....

г. Адуу

.....
.....

Дасгал ажил 10.3й. Түүхийн эрт үеэс бидэнд өвлөгдөн ирсэн соёлын өвийн талаар дараах агуулгын хүрээнд тодорхойлж бичнэ үү.

• **Өөрийн мэдэх соёлын өв :**

.....
.....

• **Соёлын өв болсон учир шалтгаан:**

.....
.....

• **Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн байдал:**

.....
.....

• **Соёлын өвийг хэрхэн хамгаалах, ямар үйл ажиллагаа зохион байгуулах талаар өөрийн саналыг бичнэ үү.**

.....
.....

.....
.....

.....
.....

Т А Н И Х Т Э М Д Э Г

Тогооны зам

Хөвдөгний үеийн Бэлэц, Ермэн

ХАНЬ УЛС

Лүүцэ устай үеэр

Хүний гэрлийн дэргийн дэргийн

Хуралданы зам

Хүннүгийн Бэлэцт, хөрөнц айлын түүвэр

ЦЭСЭШЭЛ

Нүүдлийн аймгууд

Хань улсын цэргийн дэргийн

Цагаан хэвцэр

МТ

МТЭ

Содол






Говь артайн нар

Хүннүгийн баруун тал нүүдлийн

Бүлэг сэдэв: Монголын эртний улсууд (НТӨ IV-XII зуун)
Сурагчийн овог нэр

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дууссан.... он.....сар.....өдөр....цаг

Агуулга

1. Дасгал ажлын судлах сэдвүүд	<ul style="list-style-type: none"> ❖ Хүннү гүрэн ❖ Хүннү гүрний дараах улсууд ❖ Эртний улсуудын аж ахуй, технологийн дэвшил ❖ Эртний улсуудын соёл
2. Дасгал ажлын дэвтрийн таних тэмдэг	 Сэдвийн агуулга
	 Баримт, мэдээллийг уншаад асуултад хариулаарай.
	 Дасгал ажил
	 Баримт мэдээллийг шинжлээрэй.
 Нэр томъёоны тайлбар	

Хүннү, Дунху, Юэжи улсууд НТӨ V-IV зуун	ХҮННҮ ГҮРЭН НТӨ 209-НТ 93	Сяньбийн гүрэн 156-235	СЯНЬБИЙН ҮЕ I зууны сүүл-555		ТҮРЭГ, УЙГУРЫН ҮЕ 555-IX зуун	ХЯТАН ГҮРЭН 907-1125
			Задралын үе	ЖУЖАН (330-555) Тоба Вэй (386-534) Түгүдүв (7-663)		

Товч агуулга: НТӨ III зууны сүүл үе гэхэд Хүннү хүчирхэгжив. Улмаар НТӨ 209 онд Түмэн шаньюйгийн хүү Модунь шаньюй хөрш зэргэлдээх Дунху, Юэжи зэрэг улс, аймгуудыг аймгуудыг ээлж дараалан эзэлснээр хүчирхэг Хүннү гүрнийг байгуулжээ.

НТӨ 198 онд Хүннү, Хань улсууд “энх ургийн гэрээ” байгуулсан байна. Хоёр улс хилээ Цагаан хэрмээр тогтоож, эн чацуу хүчирхэг улсууд гэдгээ хүлээн зөвшөөрч Хань улс Хүннүд жил бүр их хэмжээний татвар төлөхөөр болжээ.

Нэмэлт мэдээлэл: Теле хичээл

<https://econtent.edu.mn/lessons/EBS/10rangi/tuuh/3607>

Түүхэн хэлхээ: <https://www.youtube.com/watch?v=hD6IFQ0nkzo>

Т А Н И Х Т Э М Д Э Г

Тогооны зам

Хүннүгийн үеийн Цагаан, Бянаан

ХАНЬ УЛС

Лару улсын үе

Хүннү гүрний дэргэдэх дэргэдэх улсууд

Хуучин зам

Хүннүгийн Бянаан, Цагаан, Цагаан, Цагаан

ЦСХУ

Хүннүгийн үеийн үе

Хүннү улсын дэргэдэх дэргэдэх улсууд

Хүннүгийн үеийн үе

НТ

Монгол улс

Содол

Тогорч улсын үе

Хүннүгийн үеийн үе

Монгол улс, НТӨ III зуун

МТӨ

Монгол улс

- **Санамж:** Хүүхдүүд та бүхэн дараах дасгалыг гүйцэтгэхдээ сурах бичгийн 17-30-р талыг ашиглаарай.

Даалгавар 10.1а. Дараах үйл явдлуудыг аль улсын түүхэнд холбогдохыг тохируулан нөхөж бичнэ үү. /**Даалгаврыг гүйцэтгэхдээ дээрх он цагийн шулууныг ашиглаарай.**/

Нөхөх үгс: Сяньби, Жужан, Түрэг, Уйгур, Хятан

1. 936 онд умард Хятадыг довтлон эзэлж, гүрний шинжтэй болоод, улсаа Их Ляо гэж нэрлэв.
2. тус улсын угсааны Муюн, Тоба, Цифү, Түфа, Түгүхүн зэрэг 10 гаруй улс умард Хятадад байгуулагдав.
3. 402 онд их говийн араар нутагладаг уйгур угсааны аймгуудыг эрхшээлдээ оруулснаар хүчирхэгжив.
4. Түрэг улсыг мөхөөн өөрийн улсыг байгуулав.
5. тус улсыг үндэслэгч нь Буман бөгөөд Жужан улсын эсрэг бослогыг толгойлсон.

Даалгавар 10.1б. Дээрх үйл явдлыг үндэслэн тус улсуудыг оршин тогтнож байсан цаг хугацааны дагуу он дарааллын шулуунд тэмдэглэнэ үү.

Даалгавар 10.2а. Дараах түүхэн зүтгэлтнүүдийг амьдарч байсан цаг хугацааг нь үндэслэн он дарааллын шугам үйлдэж тэмдэглэнэ үү.

Түүхэн зүтгэлтнүүд: Буман, Модунь, Шэлүн, Амбагян, Моюнчур, Таньшихуай

Т А Н И Х Т Э М Д Э Г

Торгоны зам

Худалдааны зам

Цагаан хэвцэр

Хүннүгийн үеийн Ерэн, Ерэнэн

Урвандууны Билэст, Хэрэн, Цайны түүвэр

МТ: Манай тосголт

МТЭ: Манай тосголын өмнө

ХАНЬ УЛС

ЦСШЭЛ

Содол

Ляо улсын үер

Нүүдлийн аймгууд

Тогор уртайн нар

Хүннүгийн дэргэн дэргэлт

Ляо улсын дэргэн дэргэлт

Хүннүгийн баруун ба зүүн тал

Даалгавар 10.3а Дараах баримт сурвалжийн мэдээг харьцуулан дүгнэж эртний улсуудын аж ахуйн талаар тодорхойлж бичнэ үү.


Сурвалж 1: Тэдний малын олонх нь адуу, үхэр, хонь ямаа юм. Этгээд мал, гэвэл тэмээ, илжиг, луус юм. Тэд өвс, ус эрэн нэг нутгаас нөгөөд нүүдэг. Дотоод гадаад хэрэмтэй хот байхгүй, байнгын суурин сууц байхгүй.... Тус бүр хувь газартай...Тэд тайван цагт мал маллахын зэрэгцээ араатан, жигүүртэн агнаж амжиргаандаа нэмэрлэдэг заншилтай.
Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг УБ 1992 он

V зуунд Хятадын түүхч Фань Е-гийн эмхэтгэн бичсэн “Хожуу Хань улсын судар”-ын “Ухуань, Сяньбийн шастир”-т ухуань болон сяньбичуудын талаар дараах мэдээг өгүүлжээ.

- Эмэгтэйчүүд нь хатгамал хатгана, эсгий оёж ширдэг хийнэ. Эрэгтэйчүүд нь нум сум, эмээл хазаар хийдэг. Хүрэл, төмрийг давтан цэргийн зэвсэг үйлдэнэ.
- Их ахлагч нум сум, эмээл хазаар хийж чаддаг, алт, төмөр хайлдаг, цэргийн зэвсэг хийдэг, арьс боловсруулдаг, хээлдэг, хатгадаг, торгон утас, ноосон бөс нэхдэг.

СУРВАЛЖ

Хүннүгийн язгууртны булшнаас олдсон эд зүйлс. 1. Грек домгийн бурхад дүрсэлсэн мөнгөн эдлэл, Төв аймгийн Борнуур сумын Ноён уул. 2. Ромын шилэн аяга, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Гол мод.



СУРВАЛЖ

III зууны үеийн төмөр дөрөө.
Дорнод аймгийн Гурванзагал, Чойбалсан сумдын зааг Хөх нуурын Өгөөмөр.



Даалгавар 10.3а. Дээрх сурвалжуудыг харьцуулан судалж, дүгнэлт хийн эртний улсуудын аж ахуйн талаар тодорхойлж бичнэ үү.

а. Эртний улсууд ямар, ямар аж ахуй эрхлэж байсныг тодорхойлж бичнэ үү.

.....
.....

б.. Аж ахуйтайгаа уялдан хүмүүсийн амьдралд ямар хөгжил дэвшил гарсныг таамаглал дэвшүүлээрэй.

.....
.....
.....

в. Өнөөгийн монголчууд эртний улсын гар урлал, технологиос юу, юуг өвлөн авсан талаарх өөрийн саналыг баримт нотолгоотойгоор дэвшүүлнэ үү.

.....
.....
.....

Даалгавар 10.3б. Монгол нутаг дахь эртний улсуудын аж ахуйд хэрхэн өөрчлөлт гарсныг өмнөх үетэй нь харьцуулж бичнэ үү.

Аж ахуйн төрөл	Монголын өвөг түүхийн үе	Монголын эртний улсууд
Мал аж ахуй	- -	- -
Ан гөрөө	- -	- -
Газар тариалан	- -	- -
Гар урлал	- -	- -

- **Даалгавар 10.3в.** Дээрх сурвалжийн мэдээг үндэслэн монгол нутаг дахь эртний улсуудын мал сүргийн бүтэц, тоног хэрэглэл боловсруулах, хөдөлмөрийн багаж зэвсэг үйлдэх технологийн дэвшлийн өнөөгийн монголчуудтай ижил болон ялгаатай талыг тодорхойлж бичнэ үү.

	Ижил тал	Ялгаатай тал
Мал сүргийн бүтэц	- -	- -
Тоног хэрэглэл хийх	- -	- -
Хөдөлмөрийн багаж зэвсэг үйлдэх	- -	- -
Технологийн дэвшил	- -	- -

Даалгавар 10.1в. Дараах онд ямар үйл явдал болсныг үндэслэн ангилж бичнэ үү.

Он цаг: НТӨ 209 он, НТӨ 198 он, 48 он 93 он, 235 он, 330 он, 745 он, 840 он

Эерэг үр дагавар	Сөрөг үр дагавар

Даалгавар 10.3г. Дээрх үйл явдлаас тус бүр нэг, нэг он цагийг сонгон авч тухайн онд болсон үйл явдлын талаар дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Он цаг
Түүхэн үйл явдал		
Ач холбогдол		
Үр дагавар		
Сургамж		

Т А Н И Х Т Э М Д Э Г

Торгоны зам

Хүнлэгийн үеийн Ерэн, Ерөн

ХАНЬ УЛС

Лару улсын үед

Хүннэгийн үеийн үед

Хүннэгийн үеийн үед

Хуралданы зам

Хүнлэгийн үеийн үед, хуралданы зам

ЦЭСЭШЭ

Хүннэгийн үеийн үед

Хүннэгийн үеийн үед

Хүннэгийн үеийн үед

Цагаан хэвцэр

МНТ

МНТЭ

Содол

Содол

Содол

Содол

Даалгавар Дараах сурвалжийн мэдээг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгэн үү.

СУРВАЛЖ 2

“...Хүннүд дорнод Ху нараас элчин ирж, “танай манай хоёрын хил болох хэрмийн цаад талд эзэнгүй нутаг байна. “Та нар түүнд хүршгүй, бид авъя” гэж хэлэхэд Модунь түшмэдээсээ хэрхэхийг асуухад, зарим нь “Тэр бол эзгүй нутаг, өгч ч болно, өгөхгүй ч байж болно” гэхэд Модунь маш хилэгнэн: “Газар бол улсын үндэс мөнх, яахин өгч болно” гээд, ... мориндоо мордон, ... Дорно зүг хөдлөн дорнод ху нарыг гэнэт довтолж эзлэн авчээ..”

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 20-р тал УБ 1992 он

СУРВАЛЖ 1

“...Цагаан хэрэмнээс хойших нум сум агсагчдын улс нь шаньюйн зарлиг дагаж, Цагаан хэрэмнээс урагших түшмэдийн бүс, малгай өмсөгчид суудаг орон нь харин над захирагдана..... Хан улс, Хүннү улс хоёр бол мөр зэрэгцэх, хүчирхэг хөрш улсууд юм...”

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 21-р тал УБ 1992 он

Даалгавар 10.3д. Монгол нутаг дахь эртний улсуудын талаарх сурвалжийн мэдээг харьцуулаад дараах хүрээнд үндэслэж бичнэ үү.

	Сурвалж 1	Сурвалж 2
Шаньюйгийн үйл ажиллагааг тодорхойлно уу.		
Үйл явдлын үр дүн, ач холбогдол		
Шаньюйгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгнө үү.		
Бодит мэдээлэл мөн эсэхэд үнэлэлт өгнө үү.		

Дараах сурвалжийн мэдээг харьцуулан судалж дараах асуултад хариулна уу.

• **СУРВАЛЖ 1.**

“...Вэй улсын сүүлчээр Буман хаан теле аймгийг цэрэглэн довтолж, хиар цохиход таван түм гаруй өрх дагаар орон, чингээд Жужанд элчин илгээн ураг барилдахыг гуйхад Жужаны хаан Амгай маш хилэгнэн: “Чи миний төмөрчин боол мөн байж, яахин зүрхлэн ийм үг хэлнэм” гэж хариу элсчин илгээсэн. Тэр үед хүчирхэг болсон Түргийн хаан Буман 552 онд Жужаныг довтлон бут цохив”.

СУРВАЛЖ

Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл”-ээс.

НТӨ 138 онд Хань улсын Уди хаан Хүннүгийн эсрэг холбоотон олохын тулд цэргийн дарга Жан Цянийг Юэжид элчээр илгээжээ. Гэвч тэр Юэжид хүрэхийн тулд Хүннүгийн эзэмшил нутгийг дайрах ёстой байлаа. Жан Цянь замдаа хүннү нарт олзлогдон 10 жил Хүннүд хоригдов. Гэвч тэр Хүннүгийн удирдагчдын итгэлийг олсны дараа оргож чаджээ. Жан Цянь өнөөгийн Дундад Азиар аялаад, НТӨ 126 онд Хань улсад иргэн ирж, тайлан мэдээгээ өгчээ.

Хүннүгийн баруун өмнө, Хятадаас чанх баруун тийш 10 000 ли (5000 км) газарт Даюань (Дундад Азийн Ферганы хөндий) бий. Хүмүүс нь нэг газраа суурьшмал, газар хагалж тутарга (цагаан будаа), улаан буудай тариалдаг. Тэд мөн усан үзмээр дарс хийдэг... Даюаниас баруун тийш 2000 юм уу 3000 ли (1000 юм уу 1500 км) газар, Гүй (Амударья) голын хойно Их юэжи нар амьдарна. Тэд өмнө талаараа Дася (Дундад Азийн Бактри нутаг), баруун талаараа Анси (өнөөгийн Ираны нутагт оршин байсан Парфян улс), хойд талаараа Кангюйтай хиллэдэг. Тэд мал сүрэгтэйгээ цуг нэг газраас нөгөөд нүүдэллэдэг..., ёс заншил нь Хүннүтэй төстэй... Дасягийн зүүн өмнө Шэндүгийн (Энэтхэг) хаант улс бий. Шэндү Дасягаас хэдэн мянган ли газар гэж тэд хэлсэн. Хүмүүс нь тариа тарьж, Дасягийн хүмүүс шиг амьдарна. Тэр бүс нутгийг халуун, чийгтэй гэлцдэг. Нутгийнхан тулалдахдаа заан унадаг. Ансигаас баруун тийш хэдэн мянган газарт Тияожи (Месопотами буюу Хоёр мөрний хөндий) орших ба Баруун тэнгистэй зах нийлнэ. Халуун, чийгтэй...

[Тийнхүү Жан Цянийг эргэн ирсний дараа Хань улсаас] гадаад улсуудад (баруун зүгийн орнуудад) илгээсэн элч нарын хамгийн олон нь хэдэн зуу, хамгийн цөөн нь 100 гаруй хүнтэй байлаа.

Даалгавар 10.3е. Сурвалжийн мэдээг харьцуулан судалж хүснэгтэд буй өгөгдлийг гүйцээнэ үү.

	Сурвалж 1	Сурвалж 2
Сурвалжийн гол утга санаа		
Ижил тал		
Үйл явдлын үр дагавар		

Даалгавар 10.1г. Монгол нутаг дахь эртний улсууд ямар бичиг үсэгтэй байсан талаар холбогдох өгөгдөлтэй нь тохируулна уу.



- | | |
|----------|------------------|
| A. Хүннү | 1. Их бага бичиг |
| B. Түрэг | 2. Уйгур бичиг |
| C. Уйгур | 3. Кэмү бичиг |
| D. Хятан | 4. Руни бичиг |

Даалгавар 10.2б. Дараах археологийн дурсгалуудыг ажиглаад эртний улсуудын үед өмнөх хүрлийн үе, түрүү төмрийн үеэс өвлөж ирсэн урлагийн ямар төрөл байгааг тодорхойлно уу.

СУРВАЛЖ


Хүннүгийн язгууртны булшны эд зүйлс.

1. Алтан шармал чимэг, Хэнтий аймгийн Баян-Адрага сумын Дуурлиг нарс, 2. Нар, сар хэлбэрт алтан ялтсан чимэг, Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод, 3. Сарлагийн дүрст мөнгөн чимэг, Төв аймгийн Борнуур сумын Ноён уул.

1.



2.



3.




а)

Даалгавар 10.3ё. Дээрх археологийн дурсгалуудыг ажиглаад эртний улсуудын үеэс өнөө үед уламждаж ирсэн дүр дүрслэл юу, юу байгаа бөгөөд ямар бэлэгдлийн утгыг илэрхийлдгийг тодорхойлж бичнэ үү.

а)

б).....

Даалгавар 10.2в. Дээрх археологийн дурсгалуудыг ямар аймгийн нутгуудаас олсныг нэргүй газар зүйн зурагт / өмнөх дугаараар/ тэмдэглэнэ үү. Мөн дараах 2 дурсгалыг аль улсын үед холбогдох хаана байдгийг бие даан болон багшийн тусламжтайгаар судлан мөн газар зүйн зурагт тэмдэглээрэй.



Даалгавар 10.3ж. Дээрх хоёр дурсгалын талаар юу мэдсэн бэ? Найз нөхөд, ангийнхандаа мэдсэн зүйлийн талаар мэдээлэл, танилцуулга хийгээрэй.

а)

б).....

Даалгавар 10.3з. Өнөө үед бидэнд эртний улсуудаас өвлөгдөж ирсэн соёлын өвийн талаар юу мэдэх вэ? Түүнийг хэрхэн хамгаалах талаар өөрийн саналыг дэвшүүлнэ үү.

а)

б).....


- Товч агуулга: Монголын эртний нүүдэлчдийн соёл нь нүүдэлчдийн амьдралаас урган гарч хөгжжээ.
- Хүннү нарын үеэс уртын дуу, амьтдаар бэлгэдсэн 12 жилийн цаг тоолол хэрэглэж байжээ. Цаг тоолол нь аж ахуйгаа хөтлөх, шүтлэгийн зан үйл гүйцэтгэх, баяр, ёслол хийх, аян дайнд мордох зэрэгт чухал үүрэгтэй байв.
- Хүннү, сяньби нар чухам ямар бичиг үсэгтэй байсан тодорхойгүй ч удаах улсууд болох түрэг, уйгурууд, хятан нар өөрсдийн бичиг үсэг хэрэглэж байжээ.
- Монгол нутаг дахь эртний улсууд мал аж ахуйгаас гадна гар урлал, газар тариалан хөгжихийн зэрэгцээ хот суурин байгуулж байв.



МЭДЛЭГЭЭ ГҮНЗГИЙРҮҮЛЬЕ

Уйгурын нийслэл Харбалгас хотын туурь. Уг хотын туурь Орхон голын хөндийд Хархориноос хойш 25 км зайд (Архангай аймгийн Хотонт сумын нутагт) оршдог. Энэ хотыг 751 онд Уйгурын хаан Муюнчур үндэслэн байгуулсан бөгөөд түүний үед Уйгур улс үлэмж хүчирхэгжин манджээ. Харбалгас наанадаж 30 гаруй км² талбайг эзлэн оршин байсан нь тухайн үедээ олон хүнтэй маш том хот байсныг илтгэдэг. Харбалгас нь олон орны хүмүүс ирдэг, хана хэрэм, орд харш, сүм хийд, зах зээлийн газруудтай, худалдаа арилжаа, гар урлал, урлаг соёл өндөр хөгжсөн хот байжээ.

Даалгавар 10.2г Дараах бүс нутгийн аль хэсэгт монголын эртний улсуудын хот суурингууд төвлөрч байсныг тайлбарлаж бичнэ үү. Бие даан судлаарай.



.....

.....

Даалгавар 3.3и. Дараах сурвалжийн мэдээг анхааралтай уншаад асуултад хариулж бичнэ үү.

• **СУРВАЛЖ**

- “НТӨ 81 онд Хань улсын хааны ордонд болсон түшмэдийн эелдээн дээр хэлсэн нь: Тэдэнд ёс журмын ном байхгүй боловч, ясан дээр сийлэн модоор ороон, олон түшмэл тэмдэглэлцэх бөгөөд эзэн түшмэд, дээд дорд хэрэглэлцэнэ гэжээ”.

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 23-р тал УБ 1992 он

Дээрх сурвалжийн мэдээ нь аль улсын үед холбогдох вэ? Яагаад?

.....
.....

Тухайн улсын бичиг үсгийн талаар ямар дүгнэлт хийж болох вэ?

.....
.....

Дан ганц дээрх сурвалжийн мэдээнд үндэслэн бичиг үсэгтэй байсан гэж үзэж болох уу? Тухайн улсыг бичиг үсэгтэй байсныг гэрчлэх өөр ямар зүйлийн талаар мэдэх вэ? Өөрийн дүгнэлтийг бичнэ үү.

.....
.....
.....
.....

Даалгавар 10.3й. Дараах сурвалжийн мэдээг анхааралтай уншаад асуултад хариулж бичнэ үү.

• **СУРВАЛЖ 1**

- **Умард Вэй улсын түүхэн сурвалжаас.** 429 онд Умард Вэй улсын Шизу хаан Жужаныг довтлохоор түшмэдтэйгээ зөвлөлдөхөд ихэнх түшмэд нь Жужантай дайтах хааны саналыг дэмжсэнгүй. Тэд хаанд дараах айлтгалыг өргөв.

“Айлтгасан нь: Энэ шарагчин могой гурван билгийн жил, Бархасбадь гараг... Сугар гараг өрнө зүг байна. Цэрэг хөдөлгөж умар зүг довтолж болохгүй, яалаа ч гэсэн дээдэст золгүй болно.”

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 46-р тал УБ 1992 он

а. Дээрх сурвалжийн мэдээ нь аль улсын үед холбогдох вэ? Яагаад?

.....
.....

б. Энэ сурвалжийн мэдээнд үндэслэн ямар дүгнэлт хийж болох вэ? Энд дурдаж буй цаг тоолол нь аль улсын үеэс уламжлалтай вэ?

.....
.....

Даалгавар Дараах сурвалжийн мэдээг анхааралтай уншина уу.

СУРВАЛЖ 2.

“Шаньюй өглөө ордноосоо гарч, ургах наранд, орой саранд мөргөнө... Хойш харан сууна, зүүн талыг эрхэмлэнэ...”

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 24-р тал 1992 он

СУРВАЛЖ 3.

“Хань улсын жанжин Хо Цюйбин НТӨ 121 онд Хүннүгийн Сючу ванг довтлон түүний тэнгэр тахигдаа хэрэглэдэг алтан хөргийг олзлон аваачжээ.... Хань улсын Уди хаан алтан хөргийг Ганьцань ордондоо их шүтээн болгон тавьсань Алтан хөргийн өндөр нь 3 метр. Тахилга хойлго хийдэггүй боловч хүж асаан тавьж мөргөдөг”.

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 26-р тал 1992 он

СУРВАЛЖ 4.

“..шившлэг мэддэг лам Дармаприя (489 он) Жужаны төрийн багшаар томилон 3000 өрх соёрхсон”.

Г.Сүхбаатар Монголын түүхийн дээж бичиг 54-р тал 1992 он

Даалгавар10.3к. Дээрх сурвалжийн мэдээг харьцуулж дор өгөгдсөн даалгаврыг гүйцэтгэнэ үү.

а. Дээрх сурвалжийн 1, 2, 3, 4 мэдээнд ямар зан зүйл, юуны талаар өгүүлж байна вэ?

.....
.....

б. Дээрх эх сурвалж 1-д өгүүлж буй Хүннүгийн зан зүйл нь дараа дараагийн улсууддаа уламжлагдсан гэсэн дүгнэлтийг хийнэ үү.

.....
.....

в. Буддын шашин монголд эртний улсын үеэс дэлгэрсэн гэсэн дүгнэлтийг хийж болох уу. Яагаад?


.....
.....

г. Дээрх эх сурвалжид өгүүлж буй зан үйлээс өнөөдөр бидэнд уламжлагдан ирсэн ямар зан үйл юу байна вэ? Түүнийг жишээ гаргаж тодорхойлно уу.

.....
.....

Монголын түүх 10 хичээлийн суралцахуйн зураглал

Бүлэг сэдэв	10-р анги I-р түвшин				10-р анги II-р түвшин				10-р анги III-р түвшин												
	10.1a	10.1б	10.1в	10.1г	10.2a	10.2б	10.2в	10.2г	10.3a	10.3б	10.3в	10.3г	10.3д	10.3е	10.3ё	10.3ж	10.3з	10.3и	10.3й	10.3к	
Түүх судлах арга																					
Монголын өвөг түүх																					
Монголын эртний улсууд																					
Эхэлсэн хугацаа																					
Дууссан хугацаа																					
Өөрийн үнэлгээ																					
Багшийн үнэлгээ																					



Т А Н И Х Т Э М Д Э Г

<ul style="list-style-type: none"> Торгоны зам Худалдааны зам Шалан хаалт 	<ul style="list-style-type: none"> Хүннугийн үеийн Ертөнц, Ерөнц Хүннугийн Билэст, хэрэгцээний түүх НТ Манай тосго МТЭ Манай тосгоны өмнө 	<p style="text-align: center;">ХАНЬ УЛС</p> <ul style="list-style-type: none"> Өлрөх улсын үе Хуучин улсын үе Говь ардын үе
---	---	--